



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 5/48

Хэрлэн сум

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, 131.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтаны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх ажлыг хангалтгүй хэрэгжүүлж, малын гоц халдварт шүлхий өвчний вакцинжуулалтын ажлыг хугацаанд нь эхлүүлээгүй Биндэр сумын Засаг дарга С.Эрхэмбаярт сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж, шүлхийн вакцинжуулалтын ажлыг шуурхай эхлүүлэхийг Биндэр сумын Засаг дарга С.Эрхэмбаярт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА